



БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2025 оны 10 сарын 13 өдөр

Дугаар А/642

Булган сум

Архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх,  
хэрэглэхийг хориглох тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн хэмжээнд ээлжит цэрэг татлага, цэрэг халагдахтай холбогдуулан 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 14-ний өдрийг дуустал, Булган сумын хэмжээнд 2025 оны 10 дугаар сарын 13-ны өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 16-ны өдрийг дуустал архи, согтууруулах ундаагаар үйлчлэх, хэрэглэх, худалдан борлуулахыг түр хориглосугай.

2.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газар (цагдаагийн хурандаа Б.Эрдэнэбилэг)-т даалгасугай.

3.Захирамжийг хэрэгжүүлэн ажиллахыг архи, согтууруулах ундаа худалдах, үйлчлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж, сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Д.ПҮРЭВ-ОЧИР